

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код:

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70543156 Цахим хаяг: tserenbayrs@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 261628 Цахим хаяг: hongorzult@audit.gov.mn

Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК:
Утас: 260512 Цахим хаяг: nittsbalance@gmail.com



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

2022.02.21 № 60

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-21 №60\с

Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэн хуулийн этгээдийн эд хөрөнгийг эрхийн улсын бүртгэл хөтлөх, төрийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг УБЕГ-ын харьяа байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Бүгд найрамдах Солонгос Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага "Койка"-ийн санхүүжилтээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж буй "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд нийлүүлсэн 142,198.2 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер, техник, тоног төхөөрөмжийг дээд шатны байгууллагаас Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс шилжүүлсэн.

Орон нутгийн төсвөөс 9,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн ба эдгээр хөрөнгийг ТӨБЗГ-ын холбогдох шийдвэрийн дагуу бүртгэлд тусгасан байна.

Тайлант хугацаанд санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор Дээд шатны байгууллага Улсын бүртгэлийн ерөнхий газраас 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан ба санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг өгч ажилласан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах" зорилгын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл нь 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаанд нь 145 мэдээллийг байршуулж, төсөв, гүйцэтгэлтэй холбоотой тухай бүр бүр мэдээлэх 1, бүтэн жилээр мэдээлэх 1 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, бараа материалын нөөц, үлдэгдлийн шалтгааныг нарийвчлан тогтоох нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 51.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 5.1.5 мянган төгрөгийн алдааг залруулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагдсан	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт		2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
Эргэлтийн хөрөнгийн дүн		32.5	45.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		203.8	338.4
Нийт хөрөнгийн дүн		236.2	383.4
Нийт өр төлбөрийн дүн		0.0	0.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		236.2	383.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн		236.2	383.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
Үйл ажиллагааны орлогын дүн		733.1	772.8
Үйл ажиллагааны зардлын дүн		608.3	526.5
Үйл ажиллагааны үр дүн		124.8	147.3
Үйл ажиллагааны бус үр дүн		0.0	-0.1
Үйл ажиллагааны нийт үр дүн		124.8	147.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		47.3	236.2
Тайлант оны үр дүн		188.9	147.2
Эцсийн үлдэгдэл		236.2	383.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн		751.1	746.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		751.1	746.1
Үйл ажиллагааны ЦМГ		21.8	14.7
Хөрөнгө оруулалтын ЦМГ		-17.0	-17.2
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		438.0	437.4
Урсгал зардал		438.0	437.4
Хөрөнгийн зардал		0.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		438.0	438.0
Улсын төсвөөс санхүүжих		438.0	438.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		0.0	0.0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	51.5	1	51.5					1	0.0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	5	51.5	1	51.5					1	0.0